

25. Эзэн минь, Камеруны боловсролын бойкотыг зогсоогооч. Эдгээр сургууль, оюутнууд Тантай уулзаж, зүрх сэтгэлийн жинхэнэ өөрчлөлтийг мэдрэх болтугай. (Езек. 36:26)

26. Бурхан минь, Камеруны олон хүмүүс зэвсэгт бүлэглэлийн дайралтаас болж дотооддоо дүрвэж, үүнээс шалтгаалан тэдэнд хүмүүнлэгийн тусламж хүргэх шаардлагатай байна. Эзэн минь тэдэнд хэрэгтэй нөөцөөр нь хангаж, амар тайвныг өгөх болтугай. (Дуу. 23:1)

27. Эзэн минь ээ, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын ирэдийн дунд Эбола, улаанбурхан, холер өвчин дэгдсэн тул Та тэднийг эдгээгээч. (Дуу. 91:3)

28. Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын үргэлжилсэн зэвсэгт мөргөлдөөн нь тус улсын ард түмнийг өлсгөлөн, өвчин эмгэг, нүүлгэн шилжүүлэлтийг бий болгож байна. ТУс улсын ард түмэн Танаас амар амгаланг олох болтугай, Бурхан минь. (Иохан 16:33)


29. Эзэн минь, Төв Африкийн Бүгд Найрамдах Улсад эрт гэрлэлтийг дэмждэг хүмүүст соёлын өөрчлөлтийг авчирхад. Тэнд охидын 61% нь 18 нас хүрэхээсээ өмнө, 26% нь 15 нас хүрэхээсээ өмнө гэрлэж байна. (Дуу. 16:1).

30. Эзэн минь, Баруун болон Төв Африкийн ургацыг хамгаалж, элбэг хангалуунаар ерөөгөөч хэмээн бид залбирч байна. Ган гачиг, үер нь тэдний хүнсний хангамжийг сүйтгэхгүй байх болтугай. Эдгээр үндэстний хүнсний аюулгүй байдлыг Эзэн Та хангаач. (Дуу. 72:16)

31. Аав аа, Сьерра-Леоны хоол тэжээл, эрүүл мэндийн үйлчилгээ дутмаг байгаа хүүхдүүдэд эдгэрэлийг өгөөч. Тэдний амьдралын нөхцлийг сайжруулахын тулд арга замыг эрэлхийлж буй хүмүүст мэргэн ухааныг өгөөч. (Дэд хууль 15:11)

Монголын төлөө залбирах сэдвүүд

1. To protect children's rights and grow up in a safe environment. For girls to grow up in a society protected from violence.
2. May God-fearing leaders emerge in the parliamentary elections in 2024, create justice and equality in the society, and let all laws be made for the sake of the people.
3. Divorce rate is increasing day by day. For young people to make the right choices in life and for children to grow up in a complete family
4. For single mothers who are struggling to support their families. May God hear their voice, be their strength, protector and comfort.



Монгол сомагийн йериндл пейисбук

Монгол сомагийн йериндл хууил андл

Кудинунхэнг 851-01-0003-724 бубангсункюбангсунг

чуйчч илгун ху сабуллуо йерлак жушиси бубилнидл



Найдвартай
эмэгтэйчүүд

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2023. 12.

Баруун болон Төв Африкийн төлөөх залбирал2

Мали улс нь Баруун Африкт орших нэгэн улс бөгөөд ган гачиг, иргэний дайны улмаас бэлэвсэн эхнэр, өнчин хүүхдүүдийн тоо өдөр бүр нэмэгдсээр байгаа юм. Ийм хүнд хэцүү нөхцөлд “Найдвар доторх эмэгтэйчүүд” хөтөлбөр нь Малид эерэг нөлөөллийг нийгэмд авчирч байна. Сонсогчдын уулзалтаар хөтөлбөрийн талаар ярилцдаг бөгөөд эдгээр уулзалтад зөвхөн пасторууд төдийгүй засгийн газрын удирдагчид хүрэлцэн ирж, тус улс амар тайван улс болоход хувь нэмрээ оруулж байна.

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr
몽골 연락처 namulun89@gmail.com

1. Аав аа, манай Малигийн TWR Найдвар доторх Эмэгтэйчүүдийн багийг ашиглан олон бүлгүүдэд амар тайван, эвлэрлийн мессежийг дамжуулсаар байхад Та туслаач. (2 Кор. 5:18)

2. Эзэн минь, Малигийн баг ээж, охины чуулганыг удирдан зохион байгуулсан нь нийгэмд сайн нөлөөллийг авчран тэдний хооронд, эвлэрэл амар тайвныг өгсний төлөө бид Таныг магтъя. (Евр. 12:14)

3. Аав аа, Христэд итгэснээсээ болж хавчигдаж байгаа Нигерийн итгэгчдийг Та хамгаалаач. Энэхүү аюултай нөхцөлд амьдарч байгаа итгэгчдэд итгэлээ сахин хамгаалахад тэдний итгэлийг Та батжуулж өгөөч. (1 Петр. 3:14)

4. Бурхан минь Та, алслагдсан нутагт итгэл найдвараа алдсан эмэгтэйчүүдэд итгэл найдварын тухай хуваалцаж, Бурханы хайрыг түгээж буй Нигерийн Найдвар доторх эмэгтэйчүүд багийнханд маш их үр жимс өгөх болтугай. (Иоан 15:16)

5. Бурхан минь, бид Игбо, Нигерийн Пиджин, Хауса, Йоруба хэлээр "Найдвар доторх эмэгтэйчүүд" хөтөлбөрийг орчуулж, бүтээж, тэндхийн сая сая сонсогчдод түгээхийн тулд Нигерит санхүүжилт хангагдахын төлөө залбирч байна. (Евр. 13:20–21)

6. Их Эзэн минь, манай найдвар доторх эмэгтэйчүүд баг Нигерийн хойд хэсгийн эмэгтэйчүүдэд Библи, радиог түгээх зорилгоор Найдвар баг болон TWR-тэй хамтран ажиллаж байгаад талархаж байна. (Ном. 4:9)

7. Аав аа, Ариун Сүнс Габон дахь сүмийн удирдагчдад ухаарал хайрлаж, нутгийн иргэдэд гэрэл гэгээ, амьдрал, итгэл найдвар авчрахын төлөө залбирч байна. (Флп. 1:9)

8. Эзэн Бурхан минь, Габоны эрх баригчид болон засгийн газрын гишүүд улс орноо шударгаар удирдаж, амар тайвныг тогтоохын төлөө бид залбирч байна. (1 Тим. 2:1–2)

9. Тэнгэрлэг Эцэг минь, чамаас хол байгаа Габончууд бидний Эзэн Есүс Христийг аврах мэдлэгт хүрэх болтугай. (Үйлс 16:31)

10. Аав аа, Габоны удирдагчид улс орныхоо байгалийн баялгийг ард түмнийхээ сайн сайхны төлөө ухаалгаар ашиглахын төлөө бид залбирч байна. (1 Кор. 4:2)

11. Аав аа, Кот-д'Ивуар дахь бэлэвсэн эмэгтэйчүүд болон тэдний хүүхдүүдийг өдөр тутмын хэрэгцээгээр нь элбэг хангалуунаар хангаач. (Дуу. 68:5)



12. Кот-д'Ивуар дахь эмэгтэйчүүд, хүүхдүүдийн хамгаалагч нь Та байгаарай, Аав аа. Хулгайчид болон тэдэнд хор хөнөөл учруулахыг хүссэн бүх хүмүүс тэдэнд ойртохгүй байх болтугай. (2 Тес. 3:3)

13. Эзэн минь, Кот-д'Ивуар дахь TWR-ийн Найдвар доторх эмэгтэйчүүд багт Ямусукрогийн сонсогчдын бүлгүүдэд сургах арга хэрэгслээр хангаач. Тэдний сүнслэг амьдрал улам илүү гүнзгийрэхэд туслаач. (2 Тим. 3:16–17)

14. Аав аа, Кот-д'Ивуар дахь хөөгдсөн гудамжны болон захын худалдагч нар 2024 оны эхээр CAN гэгддэг Африкийн хөлбөмбөгийн тэмцээнд бараагаа зарах шинэ газруудыг олоход Та туслаач. (Сур. 16:3)

15. Бурхан минь, Либерийн бичиг үсэг тайлагдаагүй уншиж чаддаггүй байсан олон эмэгтэйчүүд бичиг үсэг тайлагдан уншиж сурч, залбиралын хуанлиг сар бүр уншиж байгаагийн төлөө Танд талархлыг өргөө. (Дуу. 119:18)

16. Либерид улсад олон эмэгтэйчүүд нөхөртөө хүчирхийлүүлж, бүр тэдний гарт үхэлд ч өртөж байна. Бурхан минь, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалж, тэдэнд хор хөнөөл учруулдаг эрчүүдийн зүрх сэтгэлийг өөрчилж өгөөч. (Дуу. 23:4)

17. Аав аа, Либерид гэр бүл салалт түгээмэл байдаг. Эрчүүд эхнэрээ хайрлаж, эмэгтэйчүүд нь нөхрөө хүндэлж захирагдах ёстой гэсэн Таны үгийг Либерийн хосууд дагах болтугай. (Еф. 5:22–25)

18. Бурхан минь, Либерид дэх TWR Найдвар доторх эмэгтэйчүүд үйлчлэлийг дэмжиж, хөгжүүлэхийн тулд санхүүгийн, залбиралын, сайн дурын тусламжийг өгөөч. (Флп. 4:19)

19. Эзэн минь, Сенегал дахь Найдвар доторх эмэгтэйчүүдийг багийнхан асрамжийн газар, шоронд үйлчилэхэд бусад итгэгчидтэй хамтран үйлчлэх мэргэн ухааныг өгөөч. (Дуу. 68:5–6)

20. Эзэн минь, Сенегалын тосгонд радио, мемори карт тараах нь сонсож буй хүмүүст аврал авчрах болтугай. Найдвар доторх эмэгтэйчүүд хөтөлбөрт хамрагдсанаар тэдний итгэл өсөх болтугай. (1 Петр 2:2–3)

21. Аав аа, Сенегал дахь эмэгтэйчүүд гэр бүлийнхээ амьдрах орчныг сайжруулахаар эрэлхийлж байгаа тэд ажлын байраар хангагдах болтугай. (Сур. 31:31)

22. Бурхан минь, ид шидийг үйлдэгчид Бенин дэх итгэгчдийг итгэлээ орхихыг шахан тулгаж байгаа тул Та тэдний итгэлийг хамгаалаач. (Лев. 19:31)

23. Аав аа, Бенинийн дарга нарын зүрх сэтгэлийг сайн мэдээгээр өөрчилж, тэд өөрсдийн удирдлага дор байгаа хүмүүст аврал, эрх чөлөөг авчрахад чухал үүрэг гүйцэтгэх болтугай. (1 Тим. 2:1–4)

24. Бенинд амьдрах өртөг өндрөөс болж, ядуурал маш их байна. Эзэн минь, удирдагчид болон хувираа аж ахуй эрхэлж байгаа хүмүүсийг бүтээлч сэтгэлгээгээр урамшуулан, тэдний амьдрах орчныг сайжруулахад шаардлагатай орлогыг авчрахад Та туслаач. (Дуу. 90:17)